

**Зүүн Ази Номхон Далайн бүс нутгийн түвшинд нийгмийн хариуцлага
тооцож буй арга механизм**

Л.Сарангэрэл. (Докторант)

МУБИС-ийн УТССТ-ийн багш

“Нийгмийн хариуцлага” түүнийг тооцох арга замын талаар ярихын тулд хариуцлага гэж юу болох түүний дотор нийгмийн хариуцлага гэдэг ойлголтын талаар нэгдсэн нэг тодорхой ойлголттой болох нь хамгийн чухал юм. Ингээд хариуцлага гэдэг ойлголтыг тайлбарлая.

“Хариуцлага” (Accountability) гэдэг нь үгийн утгын хувьд тайлбарлах, тайлагнах, хариуцлага хүлээх, хариуцах, тооцоо хийх зэрэг утга бүхий “to account” гэсэн үгнээс гаралтай бөгөөд утгачлан орчуулбал хариуцлага, хариуцлага хүлээх чадвар, хариуцлагатай байх гэсэн утгатай юм. Гэтэл бид (Responsibility) гэсэн ойлголтыг мөн л хариуцлага хэмээн орчуулан хэрэглэж байна. Энэ нь илүүтэй оногдсон хуваарилагдсан үүргээ биелүүлэхтэй холбоотой ойлголт ажээ. Харин хариуцлага (accountability) оногдсон үүргээ хэрхэн биелүүлсэн талаар мэдээлэл өгч, тайлбар үндэслэл тооцоог гаргаж, үйлдлийнхээ үр дагаврыг хүлээх явдал юм. Засгийн газрын эрх мэдэлтнүүд, албаны хүмүүс нь үйл ажиллагаа түүнийхээ үр дүнгийн талаар хариуцлага хүлээдэг. Өөрөөр хэлбэл тэд хуулийг сахиж, эрх мэдлээ хэтрүүлэхгүй байх, олны эрх ашиг сонирхолд үйлчлэхдээ үр ашигтай оновчтой, шударга байх зэрэг хариуцлагыг хүлээх боломжтой бөгөөд энэхүү хариуцлагыг хүлээх ёстой юм. “Хариуцлага (accountability) нь үйл ажиллагаа үйлдлийнхээ төлөө эрх мэдэлтнүүдтэй хийх тооцоо, хүлээх хариуцлага гэж хэлж болох юм. “Эрх мэдэлтнүүд” гэж улс төр, санхүүгийн болон бусад хэлбэрийн эрх мэдлийг эзэмшигчдийг хэлэх ба тэдгээрийн тоонд засгийн газар, хувийн корпораци, олон улсын санхүүгийн байгууллага, төрийн бус байгууллагын албаны хүмүүс орно”¹. Ер нь нийгмийн хариуцлага гэдэг нь зохион байгуулалттай чадваржсан иргэд төрийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн сайн

¹Дэлхийн банк. 2005. Нийгмийн хариуцлала үзэл баримтлал, шинээр гарч буй практик. УБ., хуу:9

сайхныг нэмэгдүүлэх, иргэдийн эрхийг хамгаалын төлөө иргэд төрийн үйл ажиллагаанд бүтээлчээр оролцох, түүний үр дүнг хянах үйл явц юм.

Нийгмийн хариуцлага тооцож буй бусад улс орны туршлагыг судлахад дараах арга замаар нийгмийн хариуцлага тооцдог байна. Филиппин, Энэтхэг, Украин, Малави болон Бангладеш, Канад, Дани, Швед, Их Британи, Америк зэрэг оронд дараах арга хэрэгслийг түгээмэл ашиглаж байна. Эдгээр аргууд нь Нийгмийн хариуцлага тооцоход ихээхэн үр дүнд хүргэсэн арга хэрэгслүүд болно. Үүнд:

- ✚ Иргэдийн тайлангийн карт-(Citizen's report card)
- ✚ Олон нийтийн онооны карт-(Community scoring card)
- ✚ Тайлагнах хуудас-(Reporting card)
- ✚ Бүтээлч оролцоо-(Constructive engagement)

гэх зэрэг болно. Эдгээр аргуудын талаархи ойлголт, хэрэглэх арга зам, хэрэглэсэн улсын туршлагыг доор дэлгэрэнгүй авч үзлээ.

Иргэдийн тайлангийн карт-(Citizen's report card)

Иргэдийн тайлангийн карт нь төрийн үйлчилгээний талаархи хэрэглэгчдийн санал бодлыг судалдаг оролцооны судалгаа юм. Зөвхөн мэдээлэл цуглуулахын зэрэгцээ төрийн хариуцлагатай байдлын талаар өргөн хүрээнд мэдээллийг түгээх, иргэний нийгмийн нөлөөллийн үйл ажиллагааг зэрэгцүүлэн гүйцэтгэж явдаг аргачлал юм. ИТК нь 1994 онд Энэтхэгийн Бангалор хотод бие даасан төрийн бус байгууллага болох “Олон нийтийн харилцааны төв” хэмээх байгууллага санаачилжээ. Үүний гол санаа нь хувийн хэвшлийн байгууллагууд хэрэглэгчдийн санаа бодлыг тандан судалж, үйл ажиллагаандаа тусгадаг тэрхүү практикыг төрийн бараа, үйлчилгээг хүргэх салбарт нэвтрүүлэн хэрэгжүүлэх явдал ажээ. Энэхүү судалгаа нь мэдээлэл цуглуулдаг тэрхүү аргачлалынхаа дагуу нэрлэгдсэн юм. Сургуулийн багш өөрсдийн сурагчдын хичээлээр олж авсан мэдлэгийг шалган дүн тавьдагтай адилхан ИТК нь төрийн үзүүлж буй эрүүл мэнд, боловсрол, цагдаа гэх зэрэг олон төрлийн үйлчилгээний чанар болон сэтгэл ханамжийн талаар хэрэглэгчдийн өгсөн оноо буюу дүнг нэгтгэн гаргадаг. Үүнийг өөр өөр үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүд болох хүртээмж, үйлчилгээг авах боломж, чанар, сэтгэл ханамжийг нэгдсэн байдлаар, өөр шалгуур үзүүлэл бүрээр тоон хэлбэрээр танилцуулан гаргадаг. Олон нийтийн санаа бодлыг системтэйгээр цуглуулан, түгээдэг тул ИТК нь төрөөс монополь эрхтэйгээр

үзүүлж буй үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагуудын адилаар хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцсэн байдлаар хүргэх хөшүүрэг буюу “өрсөлдөөнийг орлох үзүүлэлт” болдог. Энэ нь иргэд ямар нэгэн агентлагд өөрийн үйл ажиллагаандаа өөрчлөлт хийх хэрэгтэй гэдэг дохиог өгдөг ихээхэн ашигтай арга зам юм.²

Хэрэглэгдэх нөхцөл байдал: ИТК эрэлтийн талын мэдээлэл буюу жишээ нь төрийн үйлчилгээний чанар, сэтгэл ханамжийн талаархи хэрэглэгчдийн санал бодол зэрэг мэдээлэл байхгүй тохиолдолд үүнийг хангах зорилгоор хийгддэг. Анхлан Бангалор хотод хотын нийтийн үйлчилгээг үнэлэх зорилгоор хийгдэж эхэлсэнээс хойш ИТК нь цаашид олон янзын газар зүйн болон салбарын нөхцөлд хэрэглэж ирсэн ч үүний хамгийн гол зорилго нь хэрэглэгчдээс мэдээлэл цуглуулан энэхүү мэдээлэлд буй эрэлтийг хэрхэн хангаж буйг харьцуулах явдал байсаар ирсэн байна. ИТК-ыг ашиглах нөхцөлүүдийн хувьд:

- ИТК –ыг ядуучуудад үзүүлэх үйл ажиллагаанд суурилсан төсвийн хуваарилалтын суурь байдлаар /Филиппин/
- Төрийн үйлчилгээнд хамрагдах боломж, хэрэглээ, найдвартай байдал болон сэтгэл ханамжийг муж бүрээр харьцуулах /Энэтхэг/,
- Үндэсний хэмжээний үйлчилгээний хангамжийн судалгаанд нэгдмэл байдлаар /Уганда/,
- Засаглалын шинэтгэлийн төслүүдэд зориулан /Украйн болон Бангладеш/ хэрэглэж байна.

Ерөнхийдөө ИТК-ыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь нийт дөрвөн зүйлийг хэрхэн зөв хослуулан хэрэглэхээс хамаарч байгаагын тоонд засаглалын нийгэм эдийн засгийн нөхцөл байдал болон төрийн санхүүгийн бүтцийн талаархи ойлголт, судалгааг шинжлэх ухааны үндэстэйгээгээр гүйцэтгэн дүн шинжилгээ хийх техникийн ур чадвар, судалгаанаас гарсан үр дүнг олон нийтийн анхааралд хүргэх хэвлэл мэдээллийн болон нөлөөллийн кампанит ажил, иргэдийн хийж буй үйл ажиллагааг байнга хийгдэж байх боломжийг хангах институцын хэлбэрт оруулах зэрэг багтаж байна.

² Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхлэх хэлтэс “Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах засаглал үндсэн сэдэв ба шилдэг туршлага.” 2008. УБ., хуу:147

Иргэдийн тайлангийн картын санаачилга нь зөвхөн судалгаа хийх бус үүнээс цааших үйл ажиллагааг хамарсан үйл явц юм. Нэг талаар энэ нь “шинжлэх ухаан”- үр дүнтэй, найдвартай судалгаа явуулах, нөгөө талаас “урлаг”- хэлэлцүүлэг явуулах, үр дүнг бий болгох чиглэлийн нөлөөллийн үйл ажиллагааг өрнүүлэх сорилтыг даван туулах чадвар хэмээн тооцогддог. ИТК-ын санаачилгыг санаачилгыг хэрэгжүүлэх нь: Төрөл бүрийн оролцогч талуудын оролцоо өөр өөр түвшинд гарч ирдэг. Үүнд: Үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтүүд болон гол асуудлыг иргэдийн фокус бүлгийн хэлэлцүүлгээр тодорхойлон санал асуулгын хуудсыг боловсруулах , судалгаа хийж байх явцад буюу чанарын мэдээллээр тоон мэдээллийг бататгаж өгөхөд, олон тооны төрийн бус байгууллагуудыг цуглуулан мэдээллийг ашиглан нөлөөллийн үйл ажиллагаа явуулах болон шинэтгэл хийхэд оролцдог.³



³ www.worldbank.org/participation

ИТК-ын санаачилга нь 6 гол үе шатнаас бүрддэг.

1. Цар хүрээ, оролцогч нар болон зорилтыг тогтоох

Олон тооны салбар, нэгжүүд эсвэл оролцогч талуудын дундаас хамгийн чухал үнэлгээний цар хүрээг тухайн талуудын алинд нь хамаарахыг тогтоох явдал бөгөөд үүний тоонд аль нэг салбар уу, аж үйлдвэрийн хэсэг үү, үйлчилгээ үзүүлэгч нэгж үү гэдгийг сайтар тогтоох шаардлагатай. Ихэвчлэн судалгааг тодорхой хэмжээний судалгаа, дүн шинжилгээний туршлага бүхий зах зээлийн судалгааны байгууллагаар хийлгэдэг ба жишээ нь Энэтхэг ORG-MARG, Филиппинд Social Weather Station гэх мэт.

2. Санал асуулгын хуудсыг боловсруулах

Юуны өмнө, оролцогч талуудыг тогтоосны дараагаар фокус бүлгийн ярилцлагуудыг зохион байгуулан үүнээс гарсан үр дүнг санал асуулгын хуудсыг боловсруулахад ашиглана. Энэхүү ярилцлагыг хамгийн багадаа хоёр ерөнхий бүлэгт хийх ба үүний тоонд үйлчилгээ үзүүлэгч болон ашиглагч багтана. Санал асуулгийн хуудсыг боловсруулсаны дараа бүрэн хэмжээгээр хэрэглэж эхлэхийн өмнө үүнийг урьдчилан заавал турших шаардлагатай. Хоёрдугаарт санал асуулгын хуудсын бүтэц болон хэмжээг тогтоох хэрэгтэй ба ингэхдээ нарийвчлал болон үүнд шаардагдах цаг хугацааны тэнцлийг сайтар хангах ёстой. Судалгаа хийж буй этгээд болон судалгаанд оролцогчийн аль алинд нь хялбар байх механизмыг сайтар судлан бий болгох хэрэгтэй.

3. Түүвэрлэлт

Нэгдүгээрт, түүвэрлэлтийн хэмжээг тогтоох хэрэгтэй. Ихэвчлэн түүвэрлэлтийн хэмжээ том байх тусам сайн байдаг ч үүнийг өөрсдийн боломжит төсөв, цаг хугацаа болон хүний нөөцийн хэмжээнд тохируулан тогтоох шаардлагатай. Хамгийн гол нь тооны хойноос хөөцөлдөх бус харин илүү сайн төлөөллийг бий болгох асуудал юм. Хоёрдугаарт, тохирох түүвэрлэлтийн хэмжээг тогтоосны дараа түүвэрлэлтийн хүрээг тогтооно. Гуравдугаарт, түүвэрлэгдсэн өрхүүдийн дотор түүвэрлэлтийн оролцогч нарыг сонгоно. Ихэвчлэн гэрийн эзнийг хариулахыг хүсэх ч бүхэлдээ бол оролцогчид нь өөр өөр хүйсний, өөр өөр насны хүмүүс байдаг.

4. Судалгааг гүйцэтгэх

Судалгааг гардан гүйцэтгэх ажилтнуудыг сонгон авч сургах шаардлагатай. Судалгааны ажилтнууд нь төслийн зорилгын талаар тодорхой мэдээлэлтэй, асуулт асуух талаар ур чадвартай тэвчээртэй байхыг шаарддаг байна. Мөн өрхийн мэдээллийг тэмдэглэж авах үйл явц нь зөв явагдаж буйг баталгаажуулахын тулд сонгон авсан зарим газруудад явагдаж буй ярилцлага дээр очин мониторинг хийх нь үр дүнтэй байдаг байна.

5. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх

Энэ нь үндсэндээ гол гарцаа гаргах үе шат бөгөөд оруулсан бүх мэдээллээ нэгтгэн, дүн шинжилгээ хийдэг. Үндсэндээ оролцогч нараас төрийн үйлчилгээ, байгууллагын талаар өгсөн дүн эсвэл мэдээллийг -5-аас +5, эсвэл 1-7 хүртэл оноогоор дүгнэдэг. Үйлчилгээг төлөөлөгч нарын олон төрлийн асуултуудад өгсөн эдгээр рейтингийг дараагаар нь нэгтгэн, дундажлаж, эцэст нь сэтгэл ханамжийн оноог хувиар илэрхийлдэг. Энэ нь үндсэндээ иргэдийн тайлангын карт байдлаар харагдана гэсэн үг.

6. Түгээх

Тайлангын картнаас гарсан үр нь хамгийн гол нь зохион байгуулалт, бүтэц бүхий шүүмжлэл байх ёстой. Хэрэв судалгааны зорилго нь үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагыг магтах зорилготой бол ямарч ашиг гарахгүй. Тийм учраас анхлан гарсан үр дүнг хамгийн түрүүн тухайн судалгаанд хамрагдсан, хамаарах үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай хуваалцах ёстой. Судалгааны дараа олон нийтэд мэдээлэх стратегийг боловсруулах шаардлагатай. Судалгааны дүнг аль болох олон хүнийг хамарсан өндөр түвшний хэвлэлийн бага хурлаар зарлах хэрэгтэй. Судалгааны үр дүнг өргөн хүрээнд түгээснээр тухайн байгууллага нь үл ойшоох аргагүй болох сайн талтай юм. Тайлангын картуудыг хэвлэн нийтэлсэний дараагаар үйлчилгээ үзүүлэгч болон хэрэглэгч хоорондын нүүр тулсан уулзалтыг хотын захиргааны хэмжээнд зохион байгуулахыг санал болгодог. Ингэснээр тухайн хоёр тал нь зохион байгуулалттайгаар оролцохоос гадна үйлчилгээ үзүүлж буй байгууллагад үйл ажиллагаагаа сайжруулах шахалт үзүүлдэг. Хэрэв нэгээс илүү олон тооны байгууллагыг үнэлж байгаа бол үйлчилгээ үзүүлэгч нарын хооронд эрүүл

өрсөлдөөнийг бий болгож байдаг байна.”⁴ Мөн мэдээллийн технологийн шинэ ололтуудыг хариуцлагын холбогдолтой асуудлуудыг шийдэхэд өргөнөөр ашиглах шаардлагатай. Вебсайт болон интернет хэлэлцүүлгийг ашиглан тайлангын картын үр дүн олон нийтэд хүрэх хүртээмжийг өргөжүүлээд зогсохгүй тодорхой хэмжээний мэдлэгтэй, мэдээлэл бүхий татвар төлөгч нар олон нийтийн асуудлыг шийдэхэд оролцох оролцоог хангадаг.

Институцын хэлбэрт оруулах: ИТК-ын санаачилгууд ялангуяа анхлан хийгдэж буй тохиолдолд үүний хэрэгжилтийг ямар нэгэн хэлбэрээр институцийн хэлбэрт оруулан тогтвортой болгохгүй бол үр дүнгүй өнгөрөх нь элбэг байдаг. “Институцын хэлбэрт оруулсанаар тайлангын картын ашигтай, найдвартай байдлыг бүрэн хэмжээгээр гарган, зөвхөн үйлчилгээ үзүүлэгч нарт сэтгэл зүйн дарамт үзүүлэх бус өргөн хүрээнд хэрэглэх боломжийг ханган өгнө. Хамгийн гол нь засгийн газар нь энэхүү картыг үйл ажиллагаанд суурилсан төсөвлөлтийг хангах, олон нийтийн санал бодлыг төрийн мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбох аргачлал байдлаар мөн ашиглаж болно.”⁵ Яг ийм үйл ажиллагааг Филиппины Төсвийн яам явуулсан ба бие даасан төрийн бус байгууллагатай ИТК гэрээлэн гүйцэтгүүлсэн юм. Өөр нэг сонголт нь ИТК-ыг төвлөрлийг бууруулахад ашиглах засаглалын рейтингийн систем хэлбэрээр ашиглаж ба үүнийг Бангладеш болон Украйны Иргэдийн дуу хоолой төслүүд дээр ашиглаж байсан түүхтэй. “Үйлчилгээ үзүүлэгч нар болон яамд ИТК-ын үр дүнг өөрсдийн дотоод удирдлага болон урамшууллын системд ашиглаж болно. 1999 онд хийгдсэн Бангалорын иргэдийн ИТК нь үйлчилгээ үзүүлэгч нарыг хэд хэдэн хариу үйл ажиллагаа явуулахад хүргэсэн бөгөөд үүний тоонд Бангалорын ажлын хэсэг байгуулан энэхүү ИТК-ын санал хүсэлтүүдийг нягт авч үзэн Бангалорын хөгжлийн алба болон Усны газрын ажилтнуудад харилцагчийн үйлчилгээ, хариуцлагатай байдлын талаар сургалтын хөтөлбөр санаачилан, Карнатака хотын эрчим хүч хангамжийн газар дээр хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг гүйцэтгэжээ. Институцын хэлбэрт оруулах үйл ажиллагаа нь үндсэндээ улс төрийн хүсэл зоригоос ихээхэн хамааралтай. Үүнийг харгалзан үзсэнээр ИТК нь шинэтгэгч үзэлтэй улс төрчдөд хамгийн хэрэгтэй мэдээллийг гаргадаг бол хүнд сурталтнууд нь үргэлж үүнд саад хийж байдаг.”⁶ ИТК нь

⁴ Равиндра, А: 2004. “Бангалорийн иргэд илтгэх хуудсаар төрийн албадын ажлыг үнэлсэн нь.” ECD-ийн ажлын илтгэл, дугаар 12, Дэлхийн Банкны үйл ажиллагааны үнэлгээний хэлтэс.

⁵<http://www.icps.kiev.ua/eng/projects/pup>. вэсайтаас үзнэ үү.

⁶Равиндра, А: “Бангалорийн иргэдийн тайлангийн картын төрийн үйлчилгээнд үзүүлсэн үр нөлөө”, 2003.11 дүгээр сар хэвлэл

иргэд төрийн зүгээс илүү сайн засаглалыг шаардах аргачлал байдлаар илүүтэй ашиглагдаж байна. Гэхдээ энэхүү карт нь тодорхой хязгаарлалтгүй биш юм. Жишээ нь гол үр дүн нь хэвлэл мэдээллийн дэмжлэг болон гадны санхүүжилтээс ихээхэн хамааралтай. Төрийн ажилтнууд болон иргэдийн зүгээс үйл ажиллагааг явуулж эхлэх хүртэл тодорхой цаг болон ажлыг зарцуулах шаардлага тулгардаг. Арга зүйн хувьд ч гэсэн өөр өөр бүс нутаг салбарыг харьцуулах тал дээрх хэрэглэгчдийн үзэл бодол, хүлээлтээс хамааран хэрэглэж болохооргүй байж болно. Гэхдээ иргэдийн зүгээс улс төр болон хүнд сурталт байгууллагуудыг ИТК-ыг ашиглан хариуцлагыг шахан шаардах, үүнд энгийн иргэдийг оролцуулахад ихээхэн үр дүнтэй аргачлал болж чадах юм.

Олон нийтийн онооны карт-Community scoring cart

Олон нийтийн онооны картны (ОНОК) үйл ажиллагаа нь олон нийтэд тулгуурласан иргэдийн тайлангийн карт, олон нийтийн үнэлгээ, нийгмийн аудит хийх аргачлалаас бүрдсэн үнэлгээний холимог арга юм. Иргэдийн тайлангийн картын адил ОНОК нь нийгмийн болон олон нийтийн тайлагнах чадвар болон үйлчилгээ үзүүлэгчийн хариуцлага хоёрын нийцлийн арга хэрэгсэл болно. Хэдий ийм боловч үйлчилгээ үзүүлэгч болон олон нийтийн хоорондын уулзалтыг оруулсанаар, энэ нь шууд хариу үйлдэл өгөх боломжийг бий болгодог бөгөөд энэ үйл явц нь мөн эрх мэдэл олгох хүчтэй зэвсэг болдог.

“ОНОК-ын үйл ажиллагаа нь “олон нийтийг” дүн шинжилгээ хийх нэгж болгон ашиглах бөгөөд орон нутаг/анхан шатны түвшинд үнэлгээ хийхэд төвлөрүүлнэ. Энэ нь олон нийт өөрсдөө үйлчилгээ, төслийн хэрэгжилтийн биелэлт болон үнэлгээг чиглүүлэх бөгөөд төрийн засаг захиргаа нэгжийг хүртэл /дүүргийн хурал гэх мэт/ удирдах бүрэн боломжтой. Иргэдийн тайлангийн картын адил хэрэглэгчдийн чанар, үр өгөөж, ил тод байдлыг хүлээж авах чадварыг шаардах аргачлалыг хэрэглэснээр ОНОК-ын үйл ажиллагаа нь хөрөнгө оруулалт эсвэл зарцуулалтыг хянах, төсөл /үйлчилгээний чанарын үнэлгээ, төсөв шийдвэрлэх, нөөцийг байршуулахад ашиглаж болох үе дамжин ирсэн ажиллагааны жишиг, дүүрэг болон нэгжийн үйл ажиллагааны харьцуулалт, хэрэглэгч болон хангагчийн

хоорондын шууд хариу үйлдлийг бий болгох, орон нутгийн чадавхийг бий болгох, иргэдийн дуу хоолой болон олон нийтийн эрх мэдлийг чангатгах.”⁷

Нийгмийн болон олон нийтийн тайлагнах хэрэгсэл болохын хувьд үр ашигтай ОНОК нь ур чадвар бүхий дөрвөн зүйлийн хослолыг шаардана:

- ▶ Төрийн захиргааны нийгэм-улс төрийн тогтолцоо, төвлөрлийг багасгах түвшиний олон нийтийн санхүүгийн бүтцийг сайн ойлгох,
- ▶ Үйл ажиллагааг удирдах, зуучлах бүлгийн оюуны чадвар,
- ▶ Олон нийт болон бусад хувьцаа эзэмшигчдийн дээд зэргийн оролцоог хангах хүчтэй сурталчилгаа,
- ▶ Иргэний давтамжтай үйл ажиллагааг хууль ёсны болгоход чиглэгдсэн алхам.

Олон нийтийн онооны картын үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг

ОНОК нь өөрөө удаан хугацаагаар үргэлжлэх үйл явц биш бөгөөд нэг удаагийн олон нийтийн хурлаар ч шийдэгдэж болох асуудал. Хэдий тийм боловч, уг үйл явцын гол зорилго нь зөвхөн онооны картыг бий болгоход орших бус, зарим нэг үйлчилгээний асуудалтай холбоотой олон нийтийн хариу үйлдэл болон баримтжуулсан ойлголтыг ашиглах, бүр тодруулбал үйл ажиллагааг сайжруулах тухай юм. Энэ шалтгааны улмаас иж бүрэн ОНОК-ын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зөвхөн хэрэглэгчдийн санаа бодлыг нэгтгэсэн баримт бичгийг бий болгоод зогсохгүй харин үүний оронд ОНОК-ын үйл ажиллагаанд хамрагдах дөрвөн бүрэлдэхүүн хэсгийг урьдчилан гаргаж байна:

1. Хөрөнгө оруулалтыг хянах онооны карт
2. Олон нийтэд тулгуурласан үйл ажиллагааны онооны карт
3. Үйлчилгээ үзүүлэгчийн өөрийн үнэлгээ
4. Хэрэглэгч болон хангагчийн хоорондын шууд хариу үйлдлийг бий болгох уулзалт, харилцан ойлголцлыг тогтоох ⁸ зэрэг болно.

⁷SPACO (Гамби улс): Ядуурлыг бууруулах стратегийн зохицуулалтын албанаас гаргасан үйл ажиллагааны гарын авлага (SPA-II), 2003 оны 4 сар. www.worldbank.org/participation

⁸SPACO (Гамби улс): Ядуурлыг бууруулах стратегийн зохицуулалтын албанаас гаргасан үйл ажиллагааны гарын авлага (SPA-II), 2003 оны 4 сар. www.worldbank.org/participation

Жишээ: Малави улсын Олон нийтэд тулгуурласан үйл ажиллагааны онооны карт хэрэглэсэн байдал

<i>Д/д</i>	<i>Хэмжүүр</i>	<i>100-аас доош оноо</i>	<i>6 сарын дараа оноо</i>	<i>12 сарын дараах оноо</i>
1.	<i>Ажилтнуудын эерэг харилцаа</i>			
2.	<i>Эрүүл мэндийн төвийн зохион байгуулалт</i>			
3.	<i>Үзүүлж буй үйлчилгээний чанар</i>			
4.	<i>Олон нийтийн бүх гишүүдийн эрүүл мэндийн үйлчилгээнд эрх тэгш хамрагдаж байгаа байдал</i>			

(Эх сурвалж: Малави улсын CARE “Эрүүл мэндийн үйлчилгээний олон нийтийн онооны картнаас хийсэн судалгаа”-ны тайлангаас авав.)

Олон нийтийн онооны картын үйл ажиллагаанаас олж авсан тоо баримтыг шууд бусаар хэрэглэж болох бөгөөд түүнд байгаа мэдээллийг олон нийтийн мэдээллээр сурталчлах хэрэгтэй. Энэ нь анхан шатны мэдээллийн хэрэгсэл болох олон нийтийн радио, телевиз эсвэл үндэсний хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хийж болно. Иргэдийн талангийн карт ба Олон нийтийн онооны картын талаар дээр тодорхой авч үзсэн учир энд ялгааг нь гаргаж ирэх нь зүйтэй болов уу.

Олон нийтийн онооны карт ба Иргэдийн талангийн карт хоёрын хоорондын ялгаа

Иргэдийн талангийн карт	Олон нийтийн онооны карт
<p>-Дүгнэлт хийх нэгж нь айл өрх хувь хүн</p> <p>-Асуулт, хариулт хэлбэрээр авсан судалгааны мэдээлэл</p> <p>-Нийгмийн үе давхаргаас санамсаргүй аргаар жишээ авсан үндсэн хүн амыг төлөөлж чадахуйц албан ёсны мэдээлэл</p> <p>-Гол үр дүн нь үйлчилгээний талаархи бодит санаа бодлын үнэлгээг тайлангийн картын хэлбэрээр авах</p> <p>-Олон нийтийн хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл нь олон нийтийн санаа бодлыг цуглуулах, мэдээлэл дамжуулах явдалд гол үүрэг гүйцэтгэнэ</p> <p>-Макро түвшинд явуулах /хот, бүс, эсвэл бүр үндэсний хэмжээнд/</p> <p>-Хотжисон хэлбэрт илүү ашигтай</p> <p>-Хэрэгжилтийн цар хүрээ илүү удаан /3-6 сар орчим/</p> <p>-Мэдээлэлд дүн шинжилгээ хийх, судалгаа хийхэд зуучлагч их үүрэг гүйцэтгэнэ</p> <p>-Мэдээлэлийн хэрэгслээр сурталчилгаа хийсний дараа засаг захиргаа, үйлчилгээ үзүүлэгчдэд хариу үйлдлийн талаар мэдээлэх.</p>	<p>-Дүгнэлт хийх нэгж нь олон нийт</p> <p>-Зорилтод бүлэгтэй харилцаж цуглуулсан мэдээлэл</p> <p>-Тодорхой жишээг хамаарахгүй. Үүний оронд орон нутгийн олон нийтийг аль болох бүгдийг нь цуглаанд хамруулах</p> <p>-Онооны карт дээр бага анхаарал хандуулж хамарсан шийдвэр гаргалт, олсон ололт амжилтын талаархи шуурхай хариуд илүү анхаарал хандуулах</p> <p>-Оролцоог нэмэгдүүлэх, мэдээлэл өгөх үүднээс анхан шатны түвшинд аль болох их хүнийг дайчлах</p> <p>-Микро /орон нутгийн түвшинд явуулах (тосгон болон тухайн албан газар)</p> <p>-Хөдөө орон нутагт илүү ашигтай</p> <p>-Хэрэгжилтийн цар хүрээ харьцангуй богино /3-6 долоо хоног орчим/</p> <p>-Зуучлагч нь ихэвчлэн үйл явцыг чиглүүлэх үүрэгтэй</p> <p>-Үйлчилгээ үзүүлэгчид хүргэх хариу үйлдэл нь маш шуурхай бөгөөд харилцан ойлголцлын цуглааны үед өрнөсөн харилцан ярианы явцаас өөрчлөлт гарна.</p>

Бүтээлч оролцоо-Constructive engagement

Олон нийтийн оролцоог хязгаарлах нь эрх мэдэл цөөн хэдэн хүний гарч төвлөрөх хандлагыг бий болгодог. Төрийн аль нэг салаа мөчир эрх мэдлээ хэтрүүлж, бусдыгаа давамгайлах явдлыг гаргуулахгүй байхад үр нөлөө бүхий харилцан хяналт, тэнцвэрийг хангах тогтолцоо нэн чухал⁹. Зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх чадвар сайтай иргэний бүлгүүд, мөн сайн засаглалд иргэдийн оролцоо чухал ач холбогдолтой гэж үздэг шинэчлэлийг дэмжигч илүү хариуцлагатай төрийн албан хаагчид сүүлийн жилүүдэд үүссэн бий болсноор итгэл, түншлэлд суурилсан иргэн-засгийн газрын харилцааны нэгэн шинэ төрөл бий болсон байна.

Бүтээлч оролцоо гэдэг нь засаглалын тухайн асуудлыг хамтран шийдэхийн тулд холбогдох мэдээлэлд тулгуурлан Иргэний бүлгүүд болон Засгийн газрын хоорондоо харилцах тогтсон харилцаа холбооны нэг хэлбэр юм. Тиймээс засгийн газрыг бүхэлд нь орхигдуулдаг, ашиг сонирхол эсвэл байр сууриа илт илэрхийлдэг, сөрөг хүчний төлөө сөрөг хүчинг сурталчилдаг, мөн зөвхөн нэг удаа зөвлөгөө өгөөд, оролцоод больдог засаглалд оролцох иргэдийн оролцооны бусад хэлбэрээс ялгаатай. ямар нэгэн байдлаар зөрчилдөөнөөс урьдчилан сэргийлдэггүй боловч бүтээлч оролцоо нь асуудлын гол үндсийг хамтын хүчээр олж илрүүлэх ажлыг идэвхижүүлэх мэдээлэл солилцоо болон харилцаа холбооны шинж чанарт өөрчлөлт оруулахын тулд зөрчилтэй нөхцөл байдлыг удирдан өөрчлөх арга замыг хайдаг байна.

Нийгмий хариуцлагын хувьд бүтээлч оролцоо гэдэг нь засаглалын цөм болсон олон нийтийн эх үүсвэрийг ашиглах явцад засгийн газраас гаргах аливаа шийдвэр болон гүйцэтгэлийг хянах иргэнд суурилсан хяналтыг дэмждэг. Тиймээс энэ нь иргэдийн ойлголт, тэдний чадавхийг бүрдүүлэх, зөвлөгөө өгөхийн тулд мэдээлэл бий болгох, төлөвлөлт болон бодлого боловсруулахад нөлөөлөхийн тулд лоббидох, мөн бодлого төсөл хэрэгжүүлэхэд хамтран ажиллах зэргийг агуулсан тасралтгүй холбооны хүрээнд засаглал дах иргэдийн оролцооны нэг хурц хэлбэрийг илэрхийлнэ. Тухайлбал, иргэний бүлгүүдийн хийх төсвийн хяналт болон дүн шинжилгээний ажлын үр дүнд төлөвлөлтийн болон төсвийн чухал ач холбогдол бүхий зүйлс дунд байсан харшлах зүйлсийг илрүүлсэн ба ядуу иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн болон боловсролын анхан шатны чухал


⁹ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эдийн засаг, нийгмийн асуудал эрхлэх хэлтэс “Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах засаглал үндсэн сэдэв ба шилдэг туршлага.” 2008. УБ., хуу:83

үйлчилгээнүүдийн хуваарилалтыг нэмэгдүүлсэн байна. Төрийн үйлчилгээг үнэлэх, мөн төрийн үйлчилгээг сайжруулах аргуудыг боловсруулахаар иргэдийн мэдээлэх карт эсвэл олон нийтийн онооны картыг иргэн-засгийн газрын харилцааны үр дүнд хэрэгжүүлсэн”¹⁰.

Бүтээлч оролцоо нь “ойлголт, холбоо эсвэл магадлалыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хамтарсан судалгаан”-ы явцын хэлэлцүүлэг болон хамтран мэдээлэл цуглуулах, хэлэлцэх, хувилбаруудыг боловсруулах системчилсэн асуудал шийдвэрлэх явцыг бий болгодог. Хэлэлцүүлэг хийхэд үр дүнтэй харилцаа холбооны, үүнд мэдээ мэдээлэл, сонсох, найруулах, дахин найруулах, холбогдох хариуг хүлээн авах, өгөх зэрэг ур чадвар шаардагддаг. Асуудал шийдвэрлэхэд нөхцөл байдал болон оролцогчдод дүн шинжилгээ хийх, стратеги боловсруулах, ашиг сонирхолд суурилан хэлэлцэх, зөвшилцөлд хүрэх зэрэг дүн шинжилгээний болон шийдвэр гаргах хэрэгслүүд шаардагдана. Иргэдийн хяналтын гүйцэтгэх ажлыг нарийвчлан төлөвлөж хэрэгжүүлэх нь нийгмийн хариуцлагын ажил дах бүтээлч оролцоог бүрэн гүйцэт болгоно. Эдгээр арга хэмжээ нь хэлэлцүүлэг, хамтран асуудал шийдвэрлэх, харилцаа холбоогоо үргэлжлүүлэх, бүтээлч иргэн-засгийн газрын харилцаагаа хадгалах зэргээр эцэслэн гаргасан шийдвэрт иргэний бүлгүүдийн гол анхаарлыг хандуулдаг.

¹⁰USAID ба Олон нийтийн засаглалыг дэмжих хөтөлбөр, 2008. “Иргэний оролцоо ба хамтын засаглал: Орон нутгийн тившинд төрийн үйлчилгээг сайжруулахад тулгарч буй сорилтууд ба боломжууд. 2008 оны 8-р сар. [Http://pdf.usaid.gov/pdf_docs/PNADQ1276.Pdf](http://pdf.usaid.gov/pdf_docs/PNADQ1276.Pdf) 2010 оны 11-р сарын 9.

Нийгмийн хариуцлага дахь Бүтээлч оролцоо



Төрийн засаглалыг сайжруулах, сайн засаглалыг хөгжүүлэх, авилгатай тэмцэх, ядуурлыг бууруулах үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх зэрэг санаачлагууд нь зөвхөн төрийн дотоод хариуцлагын механизмыг сайжруулахад анхаарч ирсэн. Харин сүүлийн жилүүдээс улс төр судлаачид иргэд, иргэний нийгмийн дуу хоолой, ороолцоог нэмэгдүүлэх, хөндлөнгийн хяналтын оновчтой тогтолцоог бүрдүүлэхэд буюу нийгмийн хариуцлагын (Social accountability) асуудалд анхаарлаа хандуулах болжээ.

Монголд сүүлийн 10 жилд хөгжлийн байгууллагууд болох иргэний нийгмийн байгууллагууд төрийн албан хаагч, эрх мэдэлтнүүдэд нөлөөлөх, төрийн бодлого шийдвэр

тэдгээрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл авах, оролцох, нөлөөлөх чиглэлээр ажиллаж байна. Үүнтэй холбоотойгоор нийгмийн хариуцлагын асуудлыг анхааран ярилцах болсон бөгөөд сайн засаглалын нэгэн үзүүлэлт гэдэг утгаар судалгаа шинжилгээний бүтээлүүдэд тодорхой хэмжээгээр тусгагдаж байна. Үүний нэг жишээ нь: 2010 онд Монгол дахь Нийгмийн хариуцлагын төлөөх түншлэл¹¹ ANSA-EAP-ийн санхүүгийн болон техникийн дэмжлэгтэйгээр “Монгол дахь нийгмийн хариуцлагын дүр зургийг тодорхойлох нь” судалгааг хийсэн байна. Pacific нийгмийн хариуцлагын төлөөх сүлжээ бөгөөд анх Филиппиний Manila de Ameneo University-н Засгийн газрын сургуульд байгуулагдсан. Уг сүлжээ нь Олон Улсын Иргэний Нийгмийн Байгуулгуудын сүлжээ бөгөөд Филиппин, Индонез, Монгол, Камбож гэсэн орнуудад үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

¹¹2009 онд Ардчиллын боловсролын төв, Инфратест Нийгмийн үүрэг хариуцлагын төлөө төв, Хариуцлагатай уул уурхайн санаачлага зэрэг ТББ-ын санаачлагаар “Нийгмийн хариуцлагын төлөөх түншлэл” хэмээх сүлжээ ANSA-EAP-ийн монгол дахь сүлжээ болон байгуулагдсан.

Ном зүй

- ТББ-уудын тухай хууль (1996), Улаанбаатар
- Жилийн тайлан (2005-2009) Нээлттэй Нийгэм Форум
- Дэлхийн банк “Монголд нийгмийн хариуцлага тооцдог, хэрэгждэг орчин бий болгох нь” (2005) судалгаа
- Ц.Даваадулам, Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг, 2010
- ANSA network (2010) 4 fillers
- World Bank (2007). The enabling environment for Social Accountability in Mongolia
- Мерсу Кор (2010) Жилийн тайлан
- ИРИМ ТББ (2009) Гэрээний загвар
- Иргэд төсвөө хянана сүлжээ (2010) “Төсвийн хууль”-д ил тод, нээлттэй байдал, иргэд, ТББ-уудын оролцоог хангах заалтуудыг тусгахад чиглэсэн нөлөөллийн ажлын арга хэрэгслүүдийн төлөвлөгөө
- Байгаль орчны ТББ-уудын Иргэний зөвлөлийн жилийн тайлан (2009)
- Дэлхийн банк. 2005. Нийгмийн хариуцлага: үзэл баримтлал, шинээр гарч буй практик. УБ., хуу: 5
- Дэлхийн банк. Хариуцлага тооцоход төр, нийгмийн харицлан үйлчлэл: Дэлхийн банкинд зориулсан сургамж. Ажлын илтгэл. Дугаар 30. Вашингтон: Дэлхийн банк
- Акерман Жон (2004). “Төрийн хэвшилд зориулсан нийгмийн хариуцлага: Үзэл баримтлалын хэлэлцүүлэг”. Дэлхийн Банкинд зориулсан илтгэлийн төсөл.
- Анне Мари, ба Жон Гавента (2001) . “Үйлчилгээнд иргэдийн дуу хоолойг гаргаж, түүнийг хэрэглэгчид төвлөрүүлэх нь”, IDS –ын ажлын илтгэл, дугаар 138, Брайтон: Хөгжлийн судалгааны хүрээлэн.